



Arlington Public Schools

Department of Teaching and Learning .2110 Washington Boulevard .Arlington, Virginia 22204

SOL шалгалтад хүүхдээ оролцуулахаас татгалзсан эцэг эхийн бөглөх маягт

Холбооны болон мужийн шаардлагын дагуу Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиуд (АТӨС) хүүхдээ төгсөлтийн шаардлагыг хангахад бэлдэх нөхцлийг хангах зорилгоор Виржиниагийн Сургалтын Стандартын (SOL) шалгалтын бүх шатны түвшинд хүүхдээ оролцуулах зөвшөөрөл олгохыг эцэг эхчүүдэд уриалж байна. SOL шалгалтад хүүхдээ оролцуулахаас татгалзсан эцэг эхчүүдэд зориулсан АТӨС-ийн бодлогын талаар мэдээлэл авах хүсэлт гаргасныхаа хариуг авах бол та Виржиниа мужийн Боловсролын Газар (VDOE)-ын дор дурдсан вэб сайтаас дэлгэрэнгүй мэдээлэл, бүрдүүлэх баримт бичгийн тухай судална уу.

"Ангийн түвшин дэх бүх сурагч мужийн эсвэл холбооны хууль тогтоомж эсвэл Боловсролын зөвлөлийн дүрэм журмаар тусгайлан чөлөөлөөгүй бол Виржиниагийн үнэлгээний хөтөлбөрт хамрагдах ёстой."

<http://www.doe.virginia.gov/testing/participation/index.shtml>

SOL шалгалтанд хүүхдийг оролцуулахыг АНУ-ын Боловсролын яам, VDOE хоёулаа шаарддаг тул муж улс ч, АТӨС ч эцэг эх хүүхдээ шалгалтад оруулахаас татгалзах тохиолдолд барих бодлогоо боловсруулаагүй байна. Хүүхдээ шалгалт өгөхийг зөвшөөрөхгүй байх хүсэлт явуулж буй эцэг эхчүүдийг тухайн сургуулийнх нь төстийн албатэй холбож буй бөгөөд үүний учир нь хүүхдээ шалгалтаа өгөөгүйн үр үршгийг тэдэнд ойлгуулж, шалгалтад оруулах зөвшөөрөл олгохыг дэмжих зорилготой юм.

Эцэг эхийнхээ зөвшөөрөл өгөөгүйгээс шалтгаалан SOL шалгалтад ороогүй сурагчид шалгалтын дүнгийн NA болон дүнгийн репорт авахгүй. Энэхүү шалгалтын оноо нь сурагчийн байнгын дүн болон тэмдэглэгдэх бөгөөд сургууль, салбар болон Холбооны албан ёсны мэдээнд ордог.

SOL шалгалтад хүүхдээ оруулахаас татгалзсан эцэг эхчүүд энэхүү үйлдлийнх нь хүүхэд, сургууль, салбарт дагуулах үр нөлөөллийг ойлгож буйгаа хүлээн зөвшөөрсөн энэхүү хуудсыг бөглөн сургуульдаа өгөх шаардлагатай. Хүүхдийн шалгалтад ороогүйн учир шалтгааны тайлбар энэхүү хуудсыг хувийн хэрэгт нь хавсралт болгон хадгалах болно. Танд хэрвээ асууж, тодруулах зүйл гарвал сургуулийн захирал болон шалгалтын албатай холбогдоно уу.

Энд хавсаргасан баримт бичигтэй танилцаж хүүхэд маань SOL шалгалтад оролцоогүйгээс үүдэн гарах үр нөлөөг ойлгож буйгаа миний бие үүгээр илэрхийлж байна.

Хүүхдийн нэр: _____ Огноо: _____

Анги : _____ Сургууль: _____

Эцэг эхийн нэр (Дармалаар): _____

Эцэг эхийн гарын үсэг: _____